

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Огноо: 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр

**БАГИЙН ЭМЧ НАРЫН МОТОЦИКЛ /ХӨВСГӨЛ, АЛАГ-ЭРДЭНЭ, БАЯНЗҮРХ,
УЛААН-УУЛ, РЕНЧИНЛХҮМБЭ, ЦАГААННУУР, ЦЭЦЭРЛЭГ, ЧАНДМАНЬ-ӨНДӨР,
ХАНХ СУМ/ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТӨСЛИЙН НЭР: **Багийн эмч нарын мотоцикл /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Улаан-Уул,
Ренчинлхүмбэ, Цагааннуур, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Ханх сум/ авах**
ТЕНДЕРИЙН ДУГААР: **Г-ЭМЯ/202001056/1.5.2**

БАТЛАВ: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
ХЯНАСАН: АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

Х.ГАН-ОЧИР

Б.БОЛД

ЗӨВШӨӨРСӨН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

ГИШҮҮД:

.....

.....

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.10

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Багийн эмч нарын мотоцикл /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Ханх сум/* –ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn –ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минут*-аас өмнө *Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын “А” байр, 1 давхар, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхимд утас: 70388849, 70388848, 70388821, факс: 70388849, (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Ц.Дэлгэр)* хаягаар ирүүлнэ..

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 10 минут¹*-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг,
Орон нутгийн өмчийн газар,
аймгийн ЗДТГ-ын А байр, 114 тоот өрөө,
утас: 70388848, 70388821, 99156237, факс: 70388849**

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах
эрх олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт																	
ТӨӨЗ 1.1*	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Багийн эмч нарын мотоцикл /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Ханх сум/ авах ЭМЯ/202001056/1.5.2																	
ТӨӨЗ 1.1*	Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын төсвийн хөрөнгө оруулалт Санхүүжих дүн: 40,000,000 (Дөчин сая) төгрөг. Үүнээс 2020 онд: 40,000,000 (Дөчин сая) төгрөг.																	
ТӨӨЗ 1.1	<i>1. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материалын бичвэр дэх үсэг тоо, тэмдэгтүүд уншигдахуйц тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй тод биш баримт бичиг бүхий тендерийг ирүүлээгүйд тооцож татгалзана.</i>																	
	<i>Тендерийн хэл нь Монгол хэл байна.</i>																	
ТӨӨЗ 1.1	<p>А) Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагчид дараах нэмэлт нотлох баримтыг “нууцлахгүйгээр” тендерийн хамт ирүүлэх: Үүнд:</p> <p>1. Сүүлийн 1 жил (2019)-ийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/; Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: “тийм”, сүүлийн 1 жилд ашигтай ажилласан байна.</p> <p>2019 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх.</p> <p>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жил буюу 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь захиалагчийн санал болгож буй төсөл арга хэмжээ (багц)-ний төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх.</p> <p>2018, 2019 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайланг e-balance цахим бүртгэлд шивээгүй, баталгаажуулаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>2. Ижил төстэй барааг гэрээгээр нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 3 жил (2017, 2018, 2019 он) байх бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй бараатай ижил төстэй барааг нийлүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршилагатай байх ба энэхүү туршилагад тооцуулах гэрээ (ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй барааны төсөвт өртгийн 30 хувиас доошгүй байна.</p> <p>/"тендерээр нийлүүлэх барааны нэрийг бичнэ"-тэй ижил төрлийн барааг нийлүүлж байсан гэрээний тухай мэдээлэл/-ийг дараах хүснэгтээр нууцлахгүй ирүүлнэ:</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Гэрээний нэр</th> <th rowspan="2">Барааны нэр</th> <th rowspan="2">Гэрээний үнэ /мян.төг/</th> <th colspan="3">Захиалагчийн мэдээлэл</th> </tr> <tr> <th>Нэр</th> <th>Хаяг</th> <th>Утасны дугаар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table> <p>3. Ижил төстэй барааны нийлүүлэлтэд тооцуулах гэрээний эх хувиас татсан хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаар өмнөх захиалагчийн тодорхойлолт, барааг хүлээн авсан актын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулж, PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолтыг дараах этгээдээс гаргуулсан байна. Үүнд: Улсын төсвөөс орон нутагт эрх шилжүүлсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн гэрээний гүйцэтгэлийн тодорхойлолтыг захиалагчаар ажилласан аймаг, сумын Засаг даргын тамгын газраас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн гэрээний гүйцэтгэлийн тодорхойлолтыг захиалагчаар ажилласан яамнаас бусад эх үүсвэрээр гүйцэтгэсэн гэрээний хэрэгжилтийн талаарх тодорхойлолтыг үндсэн захиалагчаас тус тус авч ирүүлнэ. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан гэрээний мэдээллийг ижил төстэй ажилд тооцохгүй.</p> <p>ТШӨХ-ийн ТӨӨЗ 1.1-ын (А)-ын 1, ТӨӨЗ 1.1-ын (А)-ын 2, ТӨӨЗ 1.1-ын (А)-ын 3-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.</p> <p>Б) Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: шаардлагагүй</p>	№	Гэрээний нэр	Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл			Нэр	Хаяг	Утасны дугаар							
№	Гэрээний нэр					Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл										
		Нэр	Хаяг	Утасны дугаар														

4. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн² нийт дүн: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: *Захиалагчаас санал болгож буй төсөл арга хэмжээ (багу)-ний төсөвт өртгийн 30%-иас багагүй байх*

ТӨӨЗ 1.1 (Б)-ын 1.Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн заавар”-ын 3.2.2-ийн “е”-д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө =Мөнгө Түүнтэй Адилтгах Хөрөнгө +Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ” гэж заасны дагуу буюу дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:

1.1. Байгууллагын харилцагч банкин дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа (Үүгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө тооцуулах саналтай тохиолдолд дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна)

1.2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй/

1.3 Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.

Дараах тохиолдолд тендерээс татгалзана. Үүнд: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах зээл нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 1.1 (Б)-д заасан хэмжээ, өгөгдөл, шаардлагыг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.

В) Тухайн төсөл дээр ажиллуулахаар санал болгож буй инженер техникийн ажилтнууд нь дараах хүснэгтэд заасан мэргэжил ур чадвар, шалгуур, шаардлагад нийцсэн байхаар ирүүлнэ. Үүнд: №ТШМ-2-1.5

Албан тушаал	Хүний Тоо	Ажлын Гуршлага	Мэргэжил
Борлуулалтын ажилтан	1	2 жилээс дээш	Мэргэжил харгалзахгүй

ТӨӨЗ 1.1-ын (В)-ын 1. № ТШМ-2-1.5 хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтан, ажилчдын 50 –иас доошгүй хувийн нэр дээр нийгмийн даатгалын шимтгэлийг 2019 оны сүүлийн хагас жил (6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудад) оролцогч аж ахуйн нэгж өөрөө төлсөн болохыг Нийгмийн даатгалын байгууллагаас баталгаажуулсан НД№7, НД№8 маягтаар гаргасан тайланг тендерт оролцогч баталгаажуулж ирүүлнэ.

ТӨӨЗ 1.1-ын (В)-ын 2. № ТШМ-2-1.5 хүснэгтэд байгаа инженер, техникийн ажилтнууд, ажиллуулахаар санал болгож бусад мэргэжлийн ажилчдын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, ИТА-ны туршилагын талаархи мэдээллийг PDF хэлбэрт шилжүүлж тус тус ирүүлнэ. /Уг төсөлд санал болгож буй бүх ИТА, ажилчдад хамаарна/

Г) Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: *Тендерт оролцогч нь доорх хүснэгтэд заасан шалгуур, шаардлагыг хангасан машин, тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг ирүүлнэ. Үүнд: /Маягт № ТШМ-2-1.4 хүснэгт, ТӨӨЗ 1.1 (Г)-1/*

Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт	Тоо, хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар	Эзэмидэг байгууллага иргэний нэр	Чанар байдал, ашиглалтад орсон огноо

ТӨӨЗ-ийн 1.1-ийн “В, Г”-д заасан шалгуур шаардлагыг хангаагүй тендерээс татгалзана.

² Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

	<p>Д) Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг “нууцлахгүйгээр” өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерийн маягтыг тендерийн баримт бичигт заасан МАЯГТ №: ТШМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. 2. Үнийн болон бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичгийн МАЯГТ №: ТШМ-2А, 2Б, 2В-ийн аль тохирох маягтаар боловсруулж баталгаажуулан ирүүлнэ. 3. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтад заасан хугацааны дагуу баталгаажуулан ирүүлнэ, 4. Бараа нь захиалагчаас баталсан техникийн тодорхойлолт, олон улсын болон Монгол Улсын чанарын стандартыг хангасан эсэхийг гэрчлэх барааны техникийн тодорхойлолт, чанарын болон тохиролын гэрчилгээ, техникийн паспорт, ашиглалтын зааврыг тус тус ирүүлнэ. Барааны техникийн тодорхойлолтыг тендерийн баримт бичгийн гурав дугаар бүлэгт заасан загвараар гаргасан байна. Барааны чанарын болон тохиролын гэрчилгээ, техникийн паспорт, ашиглалтын заавар зэрэг баримт бичгүүд нь гадаад хэл дээр байгаа тохиолдолд баталгаат орчуулгаар Монгол хэл дээр хөрвүүлсэн байна. 5. Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, захиалагчийн санал болгосон бараа, нийлүүлэлтийн хуваарь, техникийн тодорхойлолтыг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдэлийг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг тамгаар баталгаажуулж ирүүлнэ. 6. Тендерийн баримт бичгийн ТООЗ-ын 4.2-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл ирүүлнэ. 7. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендер шалгарсан тохиодолд уг тендерийн баримт бичгийг олон нийтэд ил болгоход татгалзахгүй талаарх тендерт оролцогчийн мэдүүлэгийг эрх бүхий албан тушаалтны тамга, гарын үсгээр баталгаажуулж ирүүлнэ. 8. Захиалагчийн санаачлагаар Шүүх, харилцагч банк, Эрүүл мэнд нийгмийн даатгалын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, татварын хэлтэс, өмнө үйлчлүүлсэн захиалагчаас болон бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн агуулга бүхий мэдэгдэлийг тендерт оролцогч баталгаажуулан өөрийн тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ. 9. Тендерт санал болгож буй барааны зураг төслийг, фото зургын хамт тод харагдахуйцаар ирүүлнэ. 10. Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолд тусгагдсан дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад тусгагдсан барааны нэр төрөлд хамаарах барааг импортын бараагаар орлуулахыг хориглох тул тендерт оролцогч дээрх жагсаалтад хамаарах бараанд зөвхөн дотоодын үйлдвэрт үйлдвэрлэсэн барааг санал болгосон байна. 11. Захиалагчаас санал болгосон дотоодын барааны багцад хамаарах барааг тусад нь багцлан нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртөг, барааны техникийн тодорхойлолт, үйлдвэрлэгчийн нэр гэх мэдээллийн дагуу импортын бараанаас тусад гаргаж захиалагчаас тодорхойлсон Маягт ТШМ№2-ын аль тохирох хүснэгтээр ирүүлнэ. 12. Тендерт оролцогч нь барааны жагсаалт, үнийн хуваарь болон түүнийг дагалдах үйлчилгээний хуваарийг МАЯГТ ТШМ№1.1 МАЯГТ ТШМ№1.2 маягтаар бэлтгэн ирүүлнэ. Тендерт оролцогчийн санал болгосон барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана; <p>ТООЗ-ийн 1.1-ийн “Д”-ийн 1-12-т заасан баримт бичгийн аль нэг дутуу болон шаардлагад нийцээгүй тендерээс татгалзана.</p>
<p>ТООЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийн баримт бичгийг электрон файл хэлбэрээр хэсэг тус бүр нь 15 Мб-с хэтрэхгүй байхаар 100 Мб хүртэл хэмжээтэй PDF форматаар бэлдэж www.tender.gov.mn хаягаар илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны e-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn -ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Аймаг, хот: Хөвсгөл аймаг Мөрөн хот</p>

	<p>Улс: “Монгол Улс”</p> <p>Огноо: 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>														
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Тендер нээх байгууллагын хаяг: <i>Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын “А” байр, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхим. Өрөөний дугаар 115</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтний өрөөний дугаар 114 тоот.</i></p> <p>Огноо: 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 10 минут</p>														
	Тендерийн валют нь “Төгрөг” байна.														
ТӨӨЗ 2.3	<p>Е) Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ “нууцлахгүй” ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ; (Улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд тухайн барааны чиглэлээр гадаад, дотоод худалдаа эрхлэх чиглэлтэй байна.) 2. Тухайн үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр ажлын байрны дүгнэлтийг ирүүлнэ: “<i>Шаардлагатай</i>”, “<i>Шаардлаггүй</i>” аль нэгийг сонгох 3. Тухайн барааг тусгай зөвшөөрлийн дагуу нийлүүлэх шаардлагатай бол уг барааг нийлүүлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг наториатаар батлуулан ирүүлсэн байх; 4. Тендерт оролцогчийг төлөөлж тендерийн баримт бичиг, гэрээ, бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, гэрээний хэрэгжилтийг удирдах этгээдийн итгэмжлэл; 5. Тендер оролцогч аж ахуйн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан нь хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай болон сүүлийн 3 жилд аливаа шүүхийн зарга маргаанд хариуцагчаар оролцож ял шийтгэл, өр төлбөртэй нь тогтоогдож байгаагүй тухай Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт; Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтууд нь гаргасан өдрөөс хойш нэг сарын хугацаанд хүчинтэй байх бөгөөд тендер нээх өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. 6. Тендерт оролцогч аж ахуйн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан тендер нээх өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлгүй талаар Монгол банкны зээлийн нэгдсэн мэдээллийн сангаас гаргасан тодорхойлолт, чанаргүй зээлтэй бол Монгол банкны мэдээллийн сангаас гаргасан зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг тус тус; 7. Татвар, Нийгмийн даатгалын байгууллагад тендер нээх өдрийн байдлаар өр төлбөргүй талаар тус байгууллагуудын цахим мэдээллийн сангаас лавлагаа авч тендерт хавсарган ирүүлнэ. 8. Байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийг дараах хүснэгтээр тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга гарын үсгээр баталгаажуулсан байна. <table border="1" data-bbox="438 1451 1540 1798"> <thead> <tr> <th>Мэдээллийн нэр</th> <th>Мэдээллийн агуулга, мэдээлэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Байгууллагын нэр, регистрийн дугаар</td> <td></td> </tr> <tr> <td>Байгууллагын хаяг</td> <td></td> </tr> <tr> <td>Байгууллагын шуудангийн хаяг</td> <td></td> </tr> <tr> <td>Байгууллагатай харилцахын тулд холбогдох 3-аас доошгүй албан тушаалтан (тухайн тендер оролцогчийг төлөөлөх эрхтэй, тухайн байгууллагад ажилдаг)-ны утасны дугаар</td> <td></td> </tr> <tr> <td>Байгууллагатай харилцах албан ёсны мэйл хаяг</td> <td></td> </tr> <tr> <td>Харилцах банкны дансны дугаар</td> <td></td> </tr> </tbody> </table> <ol style="list-style-type: none"> 9. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд тендерт ирүүлсэн гэрээний үнэ, нийлүүлэлтийн хуваарьт багтаан захиалагчийн баталсан техникийн тодорхойлолт, холбогдох стандартыг хангасан барааг нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ирүүлнэ. 10. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах, гэрээг удирдах эрх бүхий албан тушаалтанд олгосон итгэмжлэлийг тендерийн баримт бичигт захиалагчаас өгсөн маягтын дагуу гаргаж ирүүлнэ. 	Мэдээллийн нэр	Мэдээллийн агуулга, мэдээлэл	Байгууллагын нэр, регистрийн дугаар		Байгууллагын хаяг		Байгууллагын шуудангийн хаяг		Байгууллагатай харилцахын тулд холбогдох 3-аас доошгүй албан тушаалтан (тухайн тендер оролцогчийг төлөөлөх эрхтэй, тухайн байгууллагад ажилдаг)-ны утасны дугаар		Байгууллагатай харилцах албан ёсны мэйл хаяг		Харилцах банкны дансны дугаар	
Мэдээллийн нэр	Мэдээллийн агуулга, мэдээлэл														
Байгууллагын нэр, регистрийн дугаар															
Байгууллагын хаяг															
Байгууллагын шуудангийн хаяг															
Байгууллагатай харилцахын тулд холбогдох 3-аас доошгүй албан тушаалтан (тухайн тендер оролцогчийг төлөөлөх эрхтэй, тухайн байгууллагад ажилдаг)-ны утасны дугаар															
Байгууллагатай харилцах албан ёсны мэйл хаяг															
Харилцах банкны дансны дугаар															

	<p>Тендерийн маягтад гарын үсэг зурах, гэрээг удирдах эрх бүхий албан тушаалтан нь гүйцэтгэх захирал байгаа тохиолдолд компанийн төлөөлөн удирдах зөвлөл (удирдлага)-өөс олгосон итгэмжлэл ирүүлнэ.</p> <p>11. Үйлдвэрлэгч нийлүүлэгчийн зөвшөөрөлийг МАЯГТ №: ТШМ-4-өөр ирүүлнэ.</p> <p>12. Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцно” Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол ТӨӨЗ 12.1 (ё)-ийн 4, 13 дахь хэсэгт заасан дотоодын бараа болохыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>12.1 Барааны гарал үүслийн гэрчилгээ</p> <p>12.2 Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт</p> <p>12.3 Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, чанарын сертификат, барааны техникийн тодорхойлолт, холбогдох стандарт,</p> <p>ТБОНӨХБАУХАТХуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 18 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно, Энэ төсөл арга хэмжээ нь бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер тул ТБОНӨХБАУХАТХ-ийн 10¹-т заасны дагуу дотоодын давуу эрх тооцно. ТӨӨЗ 2.3-ийн “Б”-ийн 1-12-т заасан баримт бичиг аль нэг дугуу, эсхүл энд заасан шалгуур шаардлагыг хангаагүй тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ	<p>Барааг хүргэх эцсийн цэг: Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил): Хөвсгөл, Мөрөн сум, Аймгийн ЗДТГ-ын байр</p>
	Барааны нийлүүлэлтэд тавих шаардлага:
ТӨӨЗ 4	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна.” Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТӨӨЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана.
ТӨӨЗ 5	Захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч барааны тохиролын болон чанарын гэрчилгээ, стандарт, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтыг тус тус нууцлахгүй ирүүлнэ. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь захиалагчийн техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна. Нийлүүлэх бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолтын аль нэг зүйл заалт, шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй байна.
Тендер шалгаруулалтын үр дүнг мэдэгдэх	Тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим систем-д нийтэлнэ. Гэрээ байгуулах эрх олгосон тухай болон тендерт шалгараагүй тухай мэдэгдлүүдийг www.umch.khs.gov.mn сайтад нийтэлж, тендерт оролцогчийн мэйл хаягаар илгээх тул тендерт оролцогч тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг энд заасан мэдээллийн хэрэгсэл, мэйл хаягаасаа үзэж мэдээлэл авах үүрэгтэй. Тендерт оролцогчийн мэйл хаяг нь алдаатай байсан болон мэйл хаягаа шалгаагүйгээс үүсэх эрсдлийг захиалагч хүлээхгүй. Мэдэгдлийн эх хувийг баталгаат шуудангаар илгээсэн өдрөөр мэдэгдэл хүргэгдсэн тооцно.
Анхааруулга	Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд хууль хяналтын байгууллага болон тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагад тус тус хандан шийдвэрлүүлнэ.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 3. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 4. Бараа хүргэх газар:** [Барааг хүлээж авах хаягийг бичнэ]
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ****1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

(А ангилал)

Огноо: _____
 Тендерийн дугаар: _____
 Тендерийн урилгын дугаар: _____
 Хувилбарт тендерийн дугаар: _____
 Хуудасны _____ -ын _____ дугаар _____

ТООЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXW бүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТООЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэххувь	ТООЗ-ны 15.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
Тендерийн нийт үнэ (10)									

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: _____
Тендерийн дугаар: _____
Тендерийн урилгын дугаар: _____
Хувилбарт тендерийн дугаар: _____

(Б ангилал)

Хуудасны _____ –ын _____

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	ТӨӨЗ-ны 15.9 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ	Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 15.9(б).(3)-д шаардсан бол)	ТӨӨЗ-ны 15.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8)
Тендерийн нийт дүн (9)								

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: _____

Тендерийн дугаар: _____

Тендерийн урилгын дугаар: _____

Хувилбарт тендерийн дугаар: _____

(В ангилал)

Хуудасны _____-ын _____

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо	Тоо ширхэг	ТӨӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ	ТӨӨЗ-ны 15.9(в).(2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ]	ТӨӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7)	ТӨӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТӨӨЗ-ны 15.9(в) (5)-д шаардсан бол)	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11)
Тендерийн нийт үнэ (12)											

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна. Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: *[тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]*

Тендерийн дугаар: *[оруул: тендер шалгаруулалтын дугаар]*

Хувилбарын дугаар: *[оруул: энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]*

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, *[оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]*-д байршилтай *[оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр]* нь *[оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]*-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр *[оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр]* компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан *[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]*, барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

1.	Гэрээний дугаар	
	Гэрээний нэр	
	Улсын нэр	
2.	Захиалагчийн нэр	
3.	Захиалагчийн хаяг	
4.	ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог	
5.	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн	
6.	Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна) Мөнгөний нэгж	Мөнгөний нэгж
7.	Гэрээний дүн: _____; Туслан гүйцэтгэх гэрээ: _____; Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _____;	Мөнгөний нэгж
8.	Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо	
9.	Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах)	
10.	Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах)	
11.	Техникийн тусгай шаардлагууд.	
12.	Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах.	

Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ. Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[моо]</i> жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. Бараа нь захиалагчаас баталсан техникийн тодорхойлолтод нийцсэн эсхийг барааны техникийн гэрчилгээ, тохиролын гэрчилгээ, чанарын сертификатын өгөгдлүүдтэй нэг бүрчлэн тулган шалгана. Барааны техникийн паспорт, чанарын болон тохиролын гэрчилгээ, үйлдвэрлэгч нийлүүлэгчийн зөвшөөрөл, техникийн тодорхойлолт нь гадаад хэл дээр багаа тохиолдолд баталгаат орчуулгаар Монгол хэл дээр хөрвүүлсэн байна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** бичгүүд:
- 1) Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт
 - 2) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 3) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 4) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 5) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 6) барааны гарал үүслийн гэрчилгээ.
 - 7) барааны техникийн тодорхойлолт,
 - 8) үйлдвэрлэгч нийлүүлэгчийн зөвшөөрөл,
 - 9) тохиролын болон чанарын сертификат
 - 10) барааны зураг, загварыг нотлох баримт бичиг

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** Баталгаат засварын тусгай шаардлага: Баталгаат засварын хугацаа 1 жил байна. Баталгаат засварын хугацааг чанарын баталгааны хугацаа гэж ойлгоно.

- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 50, 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан журманд заасан баримт бичиг, үндэслэн төлнө.

- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)³** 9.1. Алданги оногдуулах хувь: *Барааг нийлүүлэхээр тохирсон хугацаанаас хоцроож нийлүүлсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс хасна. Алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.*

Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, техникийн тодорхойлолт, үнэ, нийлүүлэх эцсийн хугацааг өөрчлөхгүй.

³ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**6. Гэрээнд
өөрчлөлт
оруулах
(ГЕН - 6)⁴**

Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**10. Гэрээг цуцлах
(ГЕН - 10)⁵**

⁴ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

⁵ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁶

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тооцоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁷;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

⁶ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁷ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]